



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/323

Чингис хот

Аймгийн хэмжээнд Үндэсний их баяр
наадам тэмдэглэхийг хориглох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 2.6, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 171 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 21 дүгээр хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавируст халдварт (COVID-19)-ын аймаг, сумдын эрсдэлийн үнэлгээг үндэслэн 2021 онд аймаг сумын хэмжээнд Үндэсний баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2.Аймгийн баяр наадамд зориулсан хөрөнгийг “Зүрх мартахгүй” төслийн зүрхний хагалгаанд хамрагдах аймгийн хүүхдүүдийн зардалд шилжүүлэх асуудлыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд уламжлан шийдвэрлүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, сумын баяр наадамд зориулсан хөрөнгийг коронавируст халдварт (COVID-19)-ын голомтыг цомхотгох арга хэмжээний зардалд шилжүүлж, зарцуулах талаар төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал боловсруулан шат шатны сумын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд уламжилж шийдвэрлэхийг сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Чогсомжав), Шуурхай штабын дарга (хурандаа Ж.Эрдэнэбат)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011706